



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 06 сарын 30 өдөр

Дугаар 4/181

Сүхбаатар сум

### Зарцуулах эрх олгох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 "а", Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.5, Сангийн сайдын 2019 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 74 дүгээр тушаалаар батлагдсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих" журмын 3.1.1, 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогыг төсвийн хүлээгдэж байгаа гүйцэтгэлд үндэслэн, төсвийн шаардлагатай зардал болон алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зардалд захиран зарцуулахыг Орон нутгийн өмчийн газрын дарга П.Эрдэнэсайханд зөвшөөрсүгэй.

2. Холбогдох журмын дагуу зарцуулалтын эрхийн баталгааг нээж олгэхыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс /О.Мөнхбаяр/-т зөвшөөрсүгэй.

3. Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогыг зарцуулсан тайланг холбогдох журмын дагуу тайлагнахыг Орон нутгийн өмчийн газар /П.Эрдэнэсайхан/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ